



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/287

Арвайхээр

**Нэмэлт ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулах  
тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 /д/, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь;

1. Тарагт суманд баригдаж буй 100 хүүхдийн дотуур байрны барилгын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Нутгийн буян групп” ХХК-тай тендерийн тоо хэмжээнд тусгагдаагүй үерийн усны хамгаалалтын далан, цахилгаан хангамж, радио холбооны кабель, бетон шал цутгах нэмэлт ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулсугай.

2. Нэмэлт гэрээ байгуулж гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэгхорол)-д даалгасугай.

3. Нэмэлт ажилд шаардагдах 48887264 (дөчин найман сая найман зуун наян долоо мянга хоёр зуун жаран дөрөв) төгрөгийг Сангийн яаманд уламжлан шийдвэрлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

0111006 7